**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

“Сэргэлэн хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/006/НА-СТА-ОНӨҮГ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ......3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН......5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА......**Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН......**Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл......**Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал......**Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт......**Error! Bookmark not defined.**
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн......**Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..**Error! Bookmark not defined.**
4.5.1 Завсрын аудитын талаар......**Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал......**Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ......8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ......10

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ААТҮГ | Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.03.13 № 357

танай___________-ны №_____________-т

"СЭРГЭЛЭН ХӨГЖИЛ" ОНӨҮГ-ЫН
ДАРГА Н.ДАВААДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Сэргэлэн хөгжил" ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй байна.

**Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг ба нийт орлого 46,650.9 мянган төгрөгийн орлого орсноос 1,750.9 мянган төгрөг буюу 3.78 хувь нь өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын удирдлага жилийн төлөвлөгөөг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

2126050194

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 8,801,723.60 | 8,491,952.34 |
| 1.1.2 | Дансны авлага | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 6,360,500.00 | 6,360,500.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 15,162,223.60 | 14,852,452.34 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 421,753,079.13 | 564,955,902.01 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | - | - |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **436,915,302.73** | **579,808,354.35** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | | |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | | |
| 2.3 | Өмч | | |
| 2.3.1 | төрийн | | |
| 2.3.2 | хувийн | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 436,915,302.73 | 579,808,354.35 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | | |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **436,915,302.15** | **579,808,354.35** |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | - | - |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг ( алдагдал) | - | - |
| 4 | Түрээсийн орлого | - | - |
| 5 | Хүүний орлого | - | - |
| 6 | Татаас санхүүжилтийн орлого | 34,932,249.00 | 45,200,000.00 |
| 7 | Үнэ төлбөргүй орсон орлого | - | 194,700,000.00 |
| 8 | Бусад орлого | 30,000,000.00 | 1,710,675.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | - | 66,853,281.12 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 83,299,900.10 | 31,727,762.26 |
| 11 | Санхүүгийн зардал | - | |
| 12 | Бусад зардал | - | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(18,367,651.10)** | **142,893,051.62** |
| 19 | Орлогын татварын зардал | - | |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **(18,367,651.10)** | **142,893,051.62** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал) | (18,367,651.10) | 142,893,051.62 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Нийт дэлгэрэнгүй орлогын дүн | - | - |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

(төгрөгөөр)

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | 455,282,953.83 | 455,282,953.83 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| **3** | Залруулсан үлдэгдэл | - | - | - |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (18,367,651.10) | (18,367,651.10) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| **9** | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | 436,915,302.73 | 436,915,302.73 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| **11** | Залруулсан үлдэгдэл | - | - | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | 142,893,051.62 | 142,893,051.62 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| **17** | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **-** | **579,808,354.35** | **579,808,354.35** |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | 34,932,249.00 | 46,910,675.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | - |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | - | - |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 35,788,300.29 | 47,220,446.26 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | - | 10,714,444.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | - | 3,179,520.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | - | - |
| 1.2.4 | Ашиглалтын зардал төлсөн | - | |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | 7,648,950.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | - | 815,327.86 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | - | 24,862,204.40 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | - | - |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 3 | Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | - | - |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | - | - |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 4 | Валютын ханшийн зөрүү | - | - |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (856,051.29) | (309,771.26) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 9,657,774.89 | 8,801,423.60 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 8,801,723.60 | 8,491,952.34 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2024 оны гүйцэтгэл | Зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| Татаас санхүүжилт | 34,932,249.00 | - | 45,200,000.00 | 45,200,000.00 | - |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | - | - | 1,710,675.00 | 1,710,675.00 | - |
| Бусад орлого | 30,000,000.00 | - | 194,700,000.00 | 194,700,000.00 | |
| **НИЙТ ОРЛОГЫН ДҮН** | **64,932,249.00** | **-** | **241,610,675.00** | **241,610,675.00** | **-** |
| Цалин хөлс | 15,840,000.00 | - | 10,714,444.00 | 10,714,444.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Байгууллага НДШ зардал | 1,980,000.00 | - | 3,179,520.00 | 3,179,520.00 | |
| Хангамжийн бараа материалын зардал | 9,674,810.00 | - | 24,862,204.40 | 24,862,204.40 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 8,293,490.29 | - | 8,464,277.86 | 8,464,277.86 | |
| Элэгдлийн зардал | 47,511,599.81 | - | 51,497,177.12 | 51,497,177.12 | |
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **83,299,900.10** | **-** | **98,717,623.38** | **98,717,623.38** | **-** |
| **ТАТВАР** | - | - | - | - | |
| **ТАТВАРЫН ДАРААХ АШИГ** | **-18,367,651.10** | **0.00** | **142,893,051.62** | **142,893,051.62** | **-** |

байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 195,161.9 мянган төгрөгийн дараах 2 алдааг[1] аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 194,700.0 мянган төгрөгөөр илүү тооцсон нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.
2. Хувь хүний орлогын албан татварын 461.9 мянган төгрөгийн төлөлтийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төрлөөр бүртгэсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

Мөн аудитаар нийт 119,301.2 мянган төгрөгийн зөрчил[2]-д 10,600.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 108,701.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 303.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

### 5.1 Албан шаардлага

1. Нохой устгалын гэрээ дээрх нийт мөнгөн дүн буруу, тус гэрээгээр 2 удаа ажил гүйцэтгэнэ гэх боловч гэрээнд 1 удаа ажил гүйцэтгэх хугацааг тусгасан, нохой устгалын 1 удаагийн 400.0 мянган төгрөгийн гэрээ болон нотлох баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь

**Commented [NA1]:** Мянган & сая

**Commented [D2R1]:** засав

**Commented [NA3]:** нягтлах

**Commented [D4R3]:** засав

---

[1] ***Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэзгүй орхисон/,***

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант хугацаанд оруулбал зохих 158 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 108,701.2 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнгээр санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг залруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

***2. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал***

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойших хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасаж тооцно", Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийг 194,700.0 мянган төгрөгөөр илүү тооцсон | 1 | 194,700.0 | | | 1 | 194,700.0 | 1 | 194,700.0 | | | | |
| Хувь хүний орлогын албан татварын 461,940 төгрөгийн төлөлтийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төрлөөр бүртгэсэн | 1 | 461,9 | | | 1 | 461,9 | 1 | 461,9 | | | | |
| Дүн | **2** | **195,161.9** | | | **2** | **195,161.9** | **2** | **195,161.9** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Commented [NA5]: Дүнг нягтлах

Commented [D6R5]: засав

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нохой усгалын гэрээ дээрх нийт мөнгөн дүн буруу, тус гэрээгээр 2 удаа ажил гүйцэтгэнэ гэх боловч гэрээнд 1 удаа ажил гүйцэтгэх | 1 | 400.0 | | | 1 | 400.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хугацааг тусгасан, нохой устгалын 1 удаагийн 400.0 мянган төгрөгийн гэрээ болон нотлох баримтгүй | | | | | | | | | | | | |
| Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 108,701.2 | | | | | 1 | 108,701.2 | | | | |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтын орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар, худалдан авалтын хасагдах татварын хэмжээг салгаж бүртгэдэггүй, тайлант хугацаанд үүссэн татварын авлага, өрийг татварын системд үүссэн дүнтэй тулгаж, тооцоо нийлж баталгаажуулдаггүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **3** | **109,101.2** | **-** | **-** | **1** | **400.0** | **2** | **108,701.2** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар | | | | | | | | | | | | |
| Тайлант хугацаанд оруулбал зохих 158 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй | 1 | 10,200.0 | | | 1 | 10,200.0 | | | | | | |
| **Дүн** | **1** | **10,200.0** | **-** | **-** | **1** | **10,200.0** | **--** | | **-** | - | - | - |